



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 293

Улаанбаатар хот

“Монгол шуудан” ТӨХК-ийн үнэт цаасыг  
үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Компанийн тухай хуулийн 11.1, 42 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 112 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2012 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 300 дугаар тогтоол, “Монгол шуудан” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2012/18 тоот тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” ТӨХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 65,727,000 /жаран таван сая долоон зуун хорин долоон мянга/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Монгол шуудан” ТӨХК /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай:

1/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

2/ Хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг мөрдөж ажиллах;

3/ Энэхүү тогтоолын 1, 2-т заасан өөрчлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, өөрчлөлтийг тэмдэглүүлэн Хороонд ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН